



МҮХАҮТ-ЫН 2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДСЭН ЧИГЛЭЛ

ЭРХЭМ ЗОРИЛГО

МҮХАҮТ нь бизнесийн таатай орчныг бүрдүүлэхэд нөлөөлөгч, өмгөөлөгч, бизнесийн хөгжилд чиглүүлэгч, холбогч, дэмжигч байна.

АЛСЫН ХАРАА


МҮХАҮТ нь бизнесийн амжилтын ТАЛБАР байж, дэлхийн зах зээлийн өрсөлдөөнд манлайлахад ХӨТӨЧ нь болно.

ҮНЭТ ЗҮЙЛС

- Чадварлаг, эвсэг хамт олон
- Нягт, үр дүнтэй хамтын ажиллагаа
- Үнэ цэнэтэй бүтээгдэхүүн, үйлчилгээ
- Ёс зүйт үйл ажиллагаа
- Манлайлал

МУХАУТ-ЫН СТРАТЕГИЙН ЗОРИЛТ

2020-2023



1. БИЗНЕСИЙН ОРЧНЫ БОЛОН БОДЛОГЫН ШИЙДЛИЙГ ТОДОРХОЙЛОХ ЧАДАМЖТАЙ БАЙХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:

1.1 Бодлогын баримт бичиг боловсруулах, хүргүүлэх

- Улсын төсвийн хүрээний мэдэгдэл ба төсвийн төсөлд санал, зөвлөмж өгөх
- Гол салбаруудаар Танхимаас баримтлах бодлогын баримт бичиг боловсруулах
- Экспорт импортын гол бараануудын статистик мэдээллийг бэлтгэх
- Макро эдийн гол үзүүлэлтүүд ба гол салбаруудын талаар мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх
- Уул уурхайн бус экспортын бүтээгдэхүүний нэр төрлийг судлан тодорхойлж экспортыг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээний цогц санал боловсруулах

1.2 Бизнесийн хууль эрх зүйн орчинг сайжруулах

Бодлогын баримт бичиг, хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгүүдэд орж ажиллан, уулзалт хэлэлцүүлгүүд зохион байгуулж, бизнес эрхлэгчдээс гарсан саналыг нэгтгэн төр засагт хүргэн ажиллах: Үүнд:

- Мэргэжлийн боловсролын тухай хуулийг УИХ-ын хэлэлцүүлэгт бэлтгэх ажлын дэд хэсэгт ажиллах
- Хөрөнгө оруулалтын тухай хуулийн ажлын хэсэгт ажиллах
- Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн ажлын хэсэгт ажиллах
- Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн ажлын хэсэгт ажиллах
- Цахим шилжилтийг эрчимжүүлэх, үйл ажиллагааг цахимжуулах, эрх зүйн орчныг бүрдүүлэх санал, шаардлагатай цахим технологийн шийдэл боловсруулж, нэвтрүүлэх үүрэг бүхий ажлын хэсэгт ажиллах
- Хууль эрх зүйн баримт бичгийн төсөлд санал боловсруулах, санал өгөх, албан хэрэг хөтлөх
- "Хувийн эрх зүйн шинэтгэл" форум зохион байгуулах
- Бизнесийн хууль эрх зүйн орчны асуудлаар уулзалт хэлэлцүүлгүүд зохион байгуулах
- Төр хувийн хэвшил түншлэлийг сайжруулах, гишүүдийг дэмжих, хөнгөлөлт урамшуулал үзүүлэх, хамтарсан арга хэмжээг цахимаар болон танхимаар тогтмол зохион байгуулах

1.3 Худалдааны гэрээ, хэлэлцээр байгуулах, хэрэгжүүлэхэд идэвхтэй хамтран ажиллах

- Монгол, Япон улс хооронд байгуулсан ЭЗТХ-ийн хэрэгжилт, тулгамдаж буй асуудлаар бизнес эрхлэгчдээс судалгаа авах, хэлэлцүүлэг уулзалт, арга хэмжээ зохион байгуулах
- Монгол улсаас БНСУ-тай байгуулах Чөлөөт Худалдааны хэлэлцээрийн судалгааны ажлын хэсэгт ажиллах

- АНДХХ /АРТА/-ийн хэрэгжилтийн талаар уулзалт, арга хэмжээ зохион байгуулах
- Евро Азийн Эдийн Засгийн Комисстой Чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах ажлын хэсэгт орж ажиллах

1.4 Танхимын хууль эрх зүйн шинэчлэлийг хийх

- Танхимын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг Засгийн газар, УИХ-аар хэлэлцүүлэх бэлтгэлийг хангах

1.5 Танхимын дэргэдэх зөвлөлүүдийн үйл ажиллагааг тогтвортой явуулах, идэвхжүүлэх

МҮХАҮТ-ын дэргэд эдийн засгийн бодлого, хууль зүйн бодлого зэрэг ерөнхий чиглэлийн, салбарын бодлогын, бизнесийн үйл ажиллагааг дэмжих, хамтын ажиллагааны чиглэлээр бизнесийн зөвлөлүүд үйл ажиллагаа явуулж байна. Зөвлөлийн үндсэн үйл ажиллагаа нь:

- Салбарын бизнес, эдийн засаг, хууль эрх зүйн орчинг сайжруулах чиглэлээр бизнес эрхлэгчдийн саналыг нэгтгэн, төр засагт хүргүүлэх
- Төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааг хөгжүүлэх
- Гишүүд хоорондын уялдаа холбоог сайжруулж, мэдээ мэдээллээр хангах

МҮХАҮТ-ЫН ДЭРГЭДЭХ ЗӨВЛӨЛҮҮД

1. Эдийн засгийн бодлогын зөвлөл
2. Хууль зүйн бодлогын зөвлөл
3. Компаенсийн үндэсний зөвлөл
4. Компанийн нийгмийн хариуцлагын зөвлөл
5. Худалдааны бодлогын зөвлөл
6. Худалдааг хөнгөвчлөх, тээвэр ложистикийн зөвлөл
7. Аялал жуулчлалын зөвлөл
8. Ноос ноолуурын зөвлөл
9. Итгэмжлэгдсэн лабораторуудын зөвлөл
10. Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих зөвлөл
11. Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн зөвлөл
12. Чөлөөт бүс хөрөнгө оруулалтын нэгдсэн зөвлөл
13. ОХУ-тай хамтран ажиллах зөвлөл
14. БНХАУ-тай хамтран ажиллах ажил хэргийн зөвлөл
15. Япон Улстай хамтран ажиллах ажил хэргийн зөвлөл
16. Монгол Туркийн хамтарсан танхим
17. Монгол Австрийн хамтын ажиллагааны зөвлөл

2. БОДЛОГОД НӨЛӨӨЛДӨГ БАЙХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:

2.1 Бизнесийн орчны судалгаа явуулах, дүн шинжилгээ хийх

- McKinsey байгууллагатай хамтарсан төсөл хэрэгжүүлэх, хамтын ажиллагааны гэрээ байгуулах
- Бизнесийн итгэлийн индекс-2022 судалгаа
- 2022 оны ТОП-100 ААН эрэмбэлэх
- Монголын бизнесийн орчны судалгаа-2023 судалгаа
- Гол нэрийн түүхий эд, бүтээгдэхүүний зах зээлийн үнийн тойм гаргах
- Сар бүрийн эдийн засаг, бизнесийн тойм гаргах
- Зах зээлийн судалгаа (тодорхой бүтээгдэхүүний зах зээлийн судалгаа, борлуулалтын судалгаа, хэрэглэгчийн зан төлвийн судалгаа, өрсөлдөгчийн судалгаа, бүтээгдэхүүн идэвхжүүлэлтийн судалгаа)
- Импортлогч аж ахуйн нэгжүүдэд тухайлсан бүтээгдэхүүний Монгол улсын зах зээлийн судалгаа хийх

2.2 Эдийн засаг, аж үйлдвэрийн салбарын мэдээллийн санг бүрдүүлэх

- Олон улс, бүс нутаг болон Монгол улсын эдийн засгийн мэдээллүүдээр мэдээллийн сан үүсгэх, тогтмол шинэчлэх
- Макро эдийн гол үзүүлэлтүүд ба гол салбаруудын талаар мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх
- Бизнес, эдийн засаг, худалдааны мэдээллийн сан үүсгэх
- ОХУ, ЕАЭК-ийн улс орнуудын худалдаа эдийн засгийн холбогдолтой нэгдсэн мэдээллийн сан үүсгэх
- ОУ-ын Худалдааг дэмжих, хөрөнгө оруулалтын байгууллагуудын мэдээллийн сан үүсгэх

3. ОЛОН НИЙТЭД НӨЛӨӨ БҮХИЙ БАЙГУУЛЛАГА БАЙЖ БИЗНЕС ЭРХЛЭГЧДИЙН НЭР ХҮНДИЙГ ӨРГӨХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:

3.1 Гишүүдийн тоог нэмэгдүүлэх

Гишүүдийн тоог 20%-аар өсгөж, сэтгэл ханамжийг 75%-д хүргэж нэмэгдүүлэх:

- Trademongolia.mn сайтын ашиглалтыг нэмэгдүүлэх, гишүүн байгууллагуудын идэвх, оролцоог нэмэгдүүлэх, олон нийтэд түгээх, шаардлагатай хөгжүүлэлтүүдийг хийх
- Гишүүд болон бизнес эрхлэгчдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн бүтээгдэхүүн үйлчилгээг хөгжүүлэх, хэрэгжүүлэх
 - Бизнес, эдийн засаг, худалдааны мэдээллийн сан үүсгэн, мэдээллийн санд тулгуурлан дата мэдээлэл бэлтгэж өгөх, судалгаа хийх үйлчилгээ үзүүлэх
 - Гадаад худалдааны үйл ажиллагааны явцад гардаг төрөл бүрийн маргааны үед талуудын аль алиных нь эрх ашгийг үл хамгаалах зарчмыг баримтлан хөндлөнгийн шалгалт (экспертиз) хийх. /Шүүхийн, Гаалийн, Даатгал, Банк, Татвар/

3.2 Гишүүд, бизнес эрхлэгчдийн гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэхэд дэмжлэг үзүүлэх

- Монгол улс болон гадаад орнуудад хийх төрийн ба бизнесийн айлчлалын хүрээнд бизнес групп, уулзалтууд зохион байгуулах
- Олон Улсын Худалдааны Танхим, Дэлхийн Танхимуудын Холбоотой мэдээлэл солилцох, зохион байгуулагдаж буй арга хэмжээнд Танхимын оролцоог хангах, хамтын ажиллагааг өргөжүүлэх
- Монгол Улсаас гадаад улсад суугаа Дипломат төлөөлөгчийн газар, Өргөмжит консулууд болон Монгол Улсад суугаа Дипломат төлөөлөгчийн газруудтай хамтын ажиллагааг идэвхжүүлэх
- Азийн худалдааг дэмжих форумтай мэдээлэл солилцох, зохион байгуулагдаж буй арга хэмжээнд МҮХАҮТ-ын оролцоог хангах, өргөжүүлэх.
- Торгоны Замын олон улсын худалдааны танхимтай хамтын ажиллагааг идэвхжүүлэх
- INTA (Олон улсын барааны тэмдэг эзэмшигчдийн холбоо)-нд Nonprofit (Associate) member гишүүний эрхийг сунгах, INTA-аас зохион байгуулж буй арга хэмжээнд оролцох, үйл ажиллагаагаа сурталчлах, гадны харилцагчдын тоог нэмэгдүүлэх

3.3 ЖДҮ эрхлэгчдийг дэмжих, хөгжүүлэх чиглэлээр төсөл хөтөлбөрүүдтэй хамтран ажиллах. Үүнд:

- Органик Монгол хөтөлбөр хэрэгжүүлэх
- Олон Улсын Худалдааны Төвийн (ITC)-ийн “She trade” төслийн салбарыг МҮХАҮТ-ын дэргэд байгуулах
- Жижиг дунд үйлдвэрийн газар, Нийслэл болон дүүргүүдийн ЖДҮ-ийг дэмжих төвтэй хамтран ажиллах

- "Аймгуудын нийгэм, эдийн засаг болон шилжилт хөдөлгөөний системийн динамик загварыг орон нутагт боловсруулахад зөвлөх үйлчилгээ үзүүлэх
- Зам дагуух үйлчилгээний цогцолбор байгуулах төслийн хэрэгжилтийг хангах, хяналт тавих
- "Бизнесийн ёс зүй, шударга байдлыг бэхжүүлэх төсөл" (2022/10-2023/10)
- Switch Asia "Монголын Сарлагийн ширний кластерыг чадавхжуулах" төсөл хэрэгжүүлэх (2021/12-2025/12)
- Азийн сан "Эмэгтэйчүүдийн эдийн засгийн чадавхыг бэхжүүлэх" төслийн үйл ажиллагаанд Танхимын оролцоог хангаж ажиллах (2022/09-2024/09)
- "Бизнес ба Хүний эрх" төслийн хэрэгжилтийг ханган ажиллах

3.4 Гишүүд, бизнес эрхлэгчдийг дэмжин урамшуулах төрөл бүрийн арга хэмжээг үр дүнтэй, шинэлэг хэлбэрээр зохион байгуулах

- Олон улсын Худалдааны Төв (ИТС)-ийн "Дэлхийн Экспортыг дэмжих форум"-ын бизнес уулзалтыг зохион байгуулах
- Монгол, ОХУ, БНХАУ-ын ХАҮТ-ын 16 дугаар нэгдсэн чуулга уулзалтыг Улаанбаатар хотноо зохион байгуулах
- "ТОП-100" ёслолын ажиллагаа
- "Үндэсний чанарын чуулган"
- Оны онцлох ААН шалгаруулах "Entrepreneur" ёслолын арга хэмжээ
- Оны шилдэг ААН-ийн туг өргөх ёслол, аян зохион байгуулах
- Эмэгтэй бизнес эрхлэгчдийн "Lady Entrepreneur" ёслолын арга хэмжээ зохион байгуулах
- "Монгол, ОХУ, БНХАУ-ын хил орчмын худалдааг дэмжих, 3 улсын эдийн засгийн коридор дахь хөгжил" үзэсгэлэн, форум БНХАУ-ын Эрээн хотод зохион байгуулах

3.5 Гишүүд, бизнес эрхлэгчдэд хэрэгцээтэй гадаад, дотоод уулзалт, хэлэлцүүлгийг үр дүнтэй зохион байгуулах

- Төр хувийн хэвшлийн түншлэлийг сайжруулах уулзалт, арга хэмжээ
- Бизнесийн байгууллагуудын хамтын ажиллагааг өргөжүүлэх, бизнесийн орчинтой холбогдох судалгаа, шинжилгээний хэлэлцүүлэг, уулзалт зохион байгуулах
- Экспортын сэдэвчилсэн судалгааны үр дүнгийн танилцуулга уулзалт зохион байгуулах, олон нийтэд мэдээлэх /мэдээлэл контент бэлтгэх/
- Бизнес итгэлийн индекс судалгааны үр дүнгийн танилцуулга уулзалт зохион байгуулах, олон нийтэд мэдээлэх /мэдээлэл контент бэлтгэх/
- Хоёр талт болон олон талт уулзалтуудыг цахимаар болон танхимаар хийх
- Монгол-ЕЭК хамтарсан бизнес форум
- Гадаад худалдааг хөгжүүлэх чиглэлээр төрөл бүрийн сургалт семинар
- Бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдэд зөвлөгөө мэдээлэл өгөх, санхүүгийн боловсролыг дээшлүүлэх хөтөлбөрт хамруулах, сургалт зохион байгуулах

3.6 Үзэсгэлэн зохион байгуулах;

- Гадаад үзэсгэлэн
 - Берлиний ногоон өдрүүд ОУ-ын үзэсгэлэн
 - Турк Измир Агро Хүнс, ХАА Мал аж ахуйн үзэсгэлэн
 - “АНУ-ын Con-Expo Барилгын үзэсгэлэн
 - Foodex Japan 48 дах удаагийн хүнсний бүтээгдэхүүний үзэсгэлэн
 - Солонгосын Олон улсын эм эмийн бүтээгдэхүүн, эмнэлгийн тоног төхөөрөмжийн үзэсгэлэн
 - CPNI Japan 2023 Эм, эмийн орц найрлага, эрүүл мэндийн тоног төхөөрөмж үзэсгэлэн
 - Farm Progress Canada Олон улсын хүнсний бүтээгдэхүүний үзэсгэлэн
 - 14 дэх удаагийн Хятад-Зүүн хойд Азийн экспо БНХАУ Жилин Чанчунь
 - БНХАУ-ын ӨМӨЗО-ны Эрээн хотод Монгол- Оросын-Хятадын 3-н талт чуулга уулзалт, үзэсгэлэн
 - 4 дэх удаагийн Монгол-Хятадын Экспо IX
 - Mining Indonesia 2023 21дэх удаагийн уул уурхайн үзэсгэлэн
 - “Sipremium sourcing fair- 2023” үзэсгэлэн
 - ANUGA 2023 Олон улсын хүнсний бүтээгдэхүүний үзэсгэлэн
 - "Canton fair 2023" үзэсгэлэн
 - БНХАУ-ын Шанхай хотноо зохион байгуулагдах 6 дахь удаагийн Хятадын Олон улсын импортын экспо
 - ХБНГУ-ын Берлин хотноо Bazaar Berlin
 - Солонгосын хүнсний үзэсгэлэн COEX FOOD WEEK
 - 35 дахь удаагийн Тайваны барилгын үзэсгэлэн
 - Эрээн хотын цагаан сарын үзэсгэлэн
- Дотоод үзэсгэлэн
 - "Жижиг дунд үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлчилгээ технологи" Олон улсын үзэсгэлэн худалдаа
 - Дэлхийн Экспортыг Хөгжүүлэх форумын үеэр B2B үзэсгэлэн зохион байгуулах ИТС
 - "Улаанбаатар түншлэл" Олон улсын үзэсгэлэн худалдаа
 - УБ Экспо төвийн бэлтгэл ажил ханган ажиллах

3.7 Салбар Танхимуудын үйл ажиллагааг дэмжих, удирдлага зохицуулалтаар хангах

- Салбар танхимуудыг мэдээ, мэдээллээр хангах
- Салбар Танхимын сумдад чиглэсэн бодлогыг хэрэгжүүлэх замаар гишүүдийн тоог 10% нэмэгдүүлэх
- Бүх салбар танхимын тайлангийн хурал, нэгдсэн семинар, Танхимын спортын арга хэмжээг зохион байгуулах, бүрэн хамруулах
- Салбар Танхимын дарга, менежерүүдэд гишүүдийн нэгдсэн бүртгэлийн систем болон trademongolia.mn сайтын ашиглалт хөгжүүлэлтийн мэдээлэл, сургалт өгөх замаар бүртгэлийг сайжруулах

- Цахим шуудан, сошиал сувгуудыг ашиглан Салбар танхимуудад бүх төрлийн мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх
- Салбар танхимын бүх гишүүдийн хурал зохион байгуулах
- Салбар Танхимын байрны асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх

3.8 Танхимын үндсэн үйлчилгээнүүдийг үзүүлэх;

- Үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийг 80% хүргэх
- Үйлчилгээний бүртгэл мэдээллийг бүрэн цахимжуулах
- Гадаад худалдаа, экспортыг дэмжих эрх зүйн орчныг боловсронгуй болгох, экспортыг нэмэгдүүлэх

Үйлчилгээ:

- Экспортын барааны гарал үүслийн гэрчилгээ
- АРТА /Ази, номхон далайн худалдааны хэлэлцээрийн хүрээнд гарал үүслийн гэрчилгээ олгох/
- ЕХ-ны REX буюу “Бүртгэгдсэн экспортлогчдын систем”-д аж ахуйн нэгжийг бүртгэх
- Аж үйлдвэрийн өмчийн эрхийн хамгаалалтыг хийх
- АТА карней формыг олгох
- Давагдашгүй хүчин зүйлийн гэрчилгээ олгох
- Органик бүтээгдэхүүн ба Ногоон буудал, Эко шошго олгох
- Газар зүйн заалт бүхий бүтээгдэхүүний хөгжүүлэлтийн ажлыг удирдан зохион байгуулах, эрхийн хамгаалалтыг хийх /Монгол улс - Европын холбоо хоорондын газар зүйн заалтын хэлэлцээрт Монгол талаас бэлтгэх ажлууд/

3.9 Гишүүн байгууллага, аж ахуйн нэгжүүдийн захирлууд, удирдах албан тушаалтнуудад манлайллын сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх, менежерийн сургалт зохион байгуулах

- Менежментийн шинэ хандлага, шилдэг арга хэрэгслийн цогц шийдлээр инновацад чиглэсэн Бизнесийг чадварлаг удирдаж, хүчирхэг компанийг бий болгох мэргэшсэн удирдлагыг бэлтгэх
- Бодит кейс дээр ажиллаж асуудлыг шийдвэрлэх оролцооны аргад суурилсан практик интерактив сургалтуудыг танхим болон цахим хэлбэрээр зохион байгуулах.

Сургалтууд:

- СТРАТЕГИ
- МЕНЕЖМЕНТ & МАНЛАЙЛАЛ
- ЭНТРЕПРЕНЕР & ИННОВАЦИ
- САНХҮҮ & ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ
- ХЭЛЦЭЛ ТОХИРОЛЦОЛ & ШИЙДВЭР ГАРГАЛТ
- КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ
- ТАЛЕНТ МЕНЕЖМЕНТ
- ГАДААД ХУДАЛДАА, САНХҮҮГИЙН МЕНЕЖЕР

3.10 Арбитр

- Арбитрын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хэвийн явуулах
- Арбитрын хуралдааныг цахим хэлбэрээр хийх
- “Цахим арбитр” төсөл хэрэгжүүлэх
- Арбитрын хэрэг хянан шийдвэрлэх дүрмийг шинэчлэн батлуулах
- Арбитрын үйл ажиллагааг олон нийтэд таниулах, сурталчлах, сургалт судалгааны чиглэлээр үйл ажиллагааг хөгжүүлэх

3.11 Маркетинг, сурталчилгааг сайжруулах

- Гишүүдийг сурталчлах
- Сарын ньуслеттер хийх
- Брэндбүүк шинэчлэх
- Олон нийтийн сүлжээний хаягуудыг идэвхтэй хөтөлж, хандалтыг нэмэгдүүлэх

4. Танхимын хүний нөөцийг чадавхжуулах, хариуцлагыг сайжруулах хүрээнд:

1. Хүний нөөцийн стратеги, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг ханган ажиллах
2. Танхимын архив, албан хэргийн хөтлөлтийг сайжруулах
3. Мэдээлэл үйлчилгээний нэгдсэн системийг шинэчлэх, хөгжүүлэх
4. Ажилтнуудыг ая тухтай ажиллах орчноор хангах